

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
 - 2.1. Санхүүгийн тайлангийн аудитын дүн
 - 2.2. Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө
3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
 - 3.1. Гүйцэтгэлийн аудитын дүн
 - 3.2. Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө
4. НИЙЦЛИЙН АУДИТ
 - 4.1 Нийцлийн аудитын дүн
 - 4.2 Нийцлийн аудитын үр нөлөө
5. БУСАД АУДИТ
6. ДОТООД АЖИЛ
7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
8. ДҮГНЭЛТ, САНАЛ
9. ХАВСРАЛТУУД

Зураг 1 Алтай сумын төсөвт байгууллагуудад Шилэн дансны цахим систем хөтлөлтийн талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байгаа нь	14
Зураг 2 Гурван талт гэрээнд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ.....	15
Зураг 3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитын инфографикийн хэсгээс.....	17
Зураг 4 МҮОНТ-ийн ярилцлага	17
Зураг 5 https://heyzine.com/flip-book хуудсанд байршуулсан СТА-ын танилцуулга	18
Зураг 6 Дотоод сургалт хэлэлцүүлэг	19
Зураг 7 Сургалт, хэлэлцүүлэг	20

ХУРААНГУЙ ТАЙЛАН

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг өргөн барьж байна.

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах” зорилтын хүрээнд 3 бүлэг 43 нэрийн ажлыг 17 орон тоотойгоор гүйцэтгэлээ.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь 143 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 138 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан үзэж, нэгдсэн удирдамжаар 3 гүйцэтгэл, 1 нийцлийн аудитыг 3 ахлах аудитор, 6 аудиторын хүчин чадлаар 3089 хүн өдөр, 6286 илүү цагаар ажиллаж 156.6 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын байгууллагын зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант жилийн болон өмнөх оноос шилжин ирсэн шийдвэрийн үлдэгдлээс орон нутгийн төсөв, сангуудын болон байгууллагын дансанд 533.6 сая төгрөгийг төвлөрүүлж, албан шаардлагаас 35,097.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 3,294.9 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж, 21,130.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 43 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн. Ингэснээр аймаг дахь Төрийн аудитын газрын нэг төгрөгт ногдох хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 76.48 төгрөг боллоо.

Санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын газар нь 143 санхүүгийн тайланд дүгнэлт гаргахаас 97 буюу 67.8 хувьд нь өөрийн хүчээр аудит хийсэн байна.

Аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулж аудит хийх гэрээгээр 46 санхүүгийн тайланд аудит хийлгэн гүйцэтгэлийг 90.2 хувиар дүгнэлээ.

Жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийг хийж, журам зааварт нийцүүлэн аудитаар илэрсэн ижил төрлийн зөрчилд нэг шийдвэр гаргах үүднээс төлбөрийн акт тогтоох, албан шаардлага, зөвлөмж өгөх судалгаа гаргаж хамт олноороо хэлэлцэн гарын авлага болгон ашиглаж байна. Нэг төрлийн зөрчилд адил, тэгш шийдвэр гаргах нь иргэдийн ТАБ-д итгэх итгэлийг нэмэгдүүлэх, аудиторын хараат бус байдлыг хамгаалах, шударга байх зарчмыг хангасан эерэг нөлөөтэй ажил гэж үздэг.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн татварын тодорхойлолтын зөрүүтэй холбоотой 1,043.3 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, татварын цахим системд залруулсан.

Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэгдээгүй 990.4 сая төгрөгийн зөрчлийн арилгаж нөхөн шивүүлсэн.

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар 3 төрлийн саналыг УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт уламжилсан. Тус саналыг аудитын нэгтгэсэн тайланд тусгасан байна.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”- д хийх нийцлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, гүйцэтгэлийн үе шатны нэгдсэн ажлын баримт, судалгааны нэгтгэлийг боловсруулан АНТАГ-ын хэмжээнд нэгтгэн аудитыг гүйцэтгэж байна.

Алба хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрууллаа.

Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 9 удаагийн сургалт, Үндэсний аудитын газраас зохион байгуулсан цахим 18 сургалт, гаднын байгууллагын 5 сургалт нийт 32 сургалтад 11 албан хаагч бүрэн хамрагдсан. Дотоод сургалтын төлөвлөгөөг 100 хангуулан ажилласан байна.

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орж 2 аудитор Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч боллоо. Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр 1 ахлах аудитор магистрын чиглэлээр суралцахаар боллоо.

Эхний хагас жилд санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт өгсөн 143 аудитын хураангуй тайланг байршуулахаас 140 хураангуй тайлан (www.open.audit.mn) цахим хуудсанд байршуулсан.

Аудитын үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээллийг Олон нийтийн Алтай радиогоор 03 дугаар сарын 20-ны өдөр мэдээлсэн.

"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийх гүйцэтгэлийн аудит болон санхүүгийн тайлангийн аудитын талаар 2023 оны 06 сарын 20-ны өдөр Монголын Үндэсний олон нийтийн телевиз болон Төр.мн цахим сайтаар мэдээлэл хийсэн.

Байгууллагын гүйцэтгэж байгаа гүйцэтгэлийн аудитын явц, гүйцэтгэлийн талаар Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газарт (www.data.audit.mn) цахим сайтад 14 хоног тутам мэдээлсэн. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гарах 143, түүвэрт хамруулсан 139 санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан үйл ажиллагаа, төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажилбарыг (www.fas.audit.mn) цахим системд оруулж 2 шатны хяналтаар хянаж 100 хувь баталгаажуулсан.

Байгууллагад ирсэн 538, явсан 364 бичгийг журмын дагуу бүртгэл хөтөлж, албан хэрэг хөтлөлтийг цаасаар болон цахимаар хослуулан бүртгэсэн. Хариутай бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийн мэдээ, тайланг 14 хоног, сар тутам тайлагнаж байна.

Байгууллагын архивд хадгалагдаж байгаа 91 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэн баримтыг хадгаламжийн нэгжийн дугаар бүрээр "PDF" өргөтгөлтэйгөөр 91 хавтас үүсгэж компьютерт болон DVD хуулж хадгаллаа.

Байгууллагын 13 албан хаагчаас нууц хамгаалах баталгааг гаргуулан авсан. Хийж гүйцэтгэсэн аудит бүрдээ нөлөөллийн мэдүүлгийн танилцуулж баримтжуулсан. Ёс зүйн дүрэм", "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам"-ыг албан хаагч бүрд танилцуулан гарын үсгээр баталгаажуулж ҮАГ-т хүргүүлсэн.

Албан хаагчдын ХАСХОМ-ийн мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авч мэдүүлгийг (meduuleg.iaac.mn) цахим сайтад баталгаажуулсан. Санхүүгийн тайлангийн аудитаар нууцад хамаарах 2 байгууллагын аудитыг гүйцэтгэхдээ тусгайлан өрөө, тасалгаа гарган өдөр тутмын хяналт тавьж ажилласан.

Манай байгууллагын хувьд төрийн аудитын байгууллагын нэр хүндийг өндөрт өргөж, өргөсөн тангарагтаа үнэнчээр аудитын чанар, үр нөлөө, үр өгөөжийг дээшлүүлэн ажиллаж байна.

Х.ТҮВШИНБАЯР

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах” зорилтын хүрээнд эхний хагас 3 бүлэг 43 нэрийн ажлыг 17 орон тоотойгоор гүйцэтгэлээ. Тус зорилтын хүрээнд төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг 100 хувь хангуулан ажиллалаа.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс гадна удирдлагын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төрийн аудитын дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө, иргэдийн оролцооны хангах стратеги төлөвлөгөө, харилцагч талуудын оролцооны төлөвлөгөө, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тасралтгүй сургалтын төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Албан хаагчдын цаг ашиглалт, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг (www.able.audit.mn) цахим системээр хянан хянан удирдах, дотоод мэдээлэл солилцох, цаасны хэрэглээг 2.4 сая төгрөгөөр бууруулан өдөр тутмын хэрэглээнд ашиглаж байна.

Аудитын үйл ажиллагааны талаар:

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь 143 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 138 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан үзэж, нэгдсэн удирдамжаар 3 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудитыг 3 ахлах аудитор, 6 аудиторын хүчин чадлаар 3,089 хүн өдөр, 6286 илүү цагаар ажиллаж 156.6 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэлээ.

Бид 2023 оны аудитаар 43,242.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 18,006.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж 17,185.7 сая төгрөгийн зөрчилд 968 албан шаардлага, 6,787.2 сая төгрөгийн зөрчилд 324 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, 1,245.7 сая төгрөгийн зөрчилд 324 төлбөрийн акт тогтоосон. Ажлын хариуцлага алдсан 62 албан тушаалтан хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. Мөн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 16.8 сая төгрөгийн асуудлыг МУЕА-т албан бичгээр уламжилсан.

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар 3 төрлийн саналыг УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт уламжилж, нэгтгэсэн тайланд тусгасан байна.

Мөн Хоршоо хөгжүүлэх сангийн гэрээний хугацаа хэтэрсэн 36 зээлдэгчийн 194.5 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн гэрээний хугацаа хэтэрсэн 1 зээлдэгчийн 56.3 сая төгрөг, Мал хамгаалах сангийн хугацаа хэтэрсэн 31 зээлдэгчийн 31.5 сая төгрөг, Тариалан эрхлэгчдийг дэмжих сангийн хугацаа хэтэрсэн 56 зээлдэгчийн 77.9 сая төгрөгийн зээлийг хугацаандаа төлөөгүй, авлагыг эвлэрлийн гэрээний хугацаа дууссан байхад төр хохирч байгаа үйлдэлд төрийн ашиг сонирхлыг хамгаалах итгэмжлэлээр оролцож хохирлыг холбогдох этгээдээр төлүүлж, эвлэрлийн гэрээний хугацаа дууссан тул албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулах талаар аймгийн Прокурорын газарт хүргүүлсэн.

Эхний хагас жилийн болон өмнөх оноос шилжин ирсэн шийдвэрийн үлдэгдлээс 2023 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар орон нутгийн төсөв, сангуудын болон байгууллагын дансанд 533.6 сая төгрөгийг төвлөрүүлж, албан шаардлагаас 35,097.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 3,294.9 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж, 21,130.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 43 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагууд албан бичиг, нотлох баримтаар хүлээн зөвшөөрсөн.

Ингэснээр Төрийн аудитын газрын нэг төгрөгт ногдох хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 76.48 төгрөг боллоо.

Байгууллагын цаг үеийн мэдээлэл, аудитын тайлан, танилцуулгыг инфографик, зурагт хуудас, виртуал тайлан хэлбэрээр (www.open.audit.mn) цахим хуудас болон “Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар” фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлэл түгээж ажиллалаа. Мөн нэгдсэн удирдамжаар хийсэн 2 гүйцэтгэл, 1 нийцлийн аудитын тайланг ҮАГ-т able программаар, аймаг, сумдын ИТХ, ЗДТГ-т <http://eoffice.govi-altai.gov.mn>) цахим системээр хүргүүлсэн.

ХОЁР. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН

Аудитын дүнгээр Төрийн аудитын газрын хэмжээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн шууд захирагчийн 106, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 21, засгийн газрын тусгай сан, төсөл хөтөлбөрийн 2, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 13 нийт 193 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. Төрийн аудитын байгууллагад Дарив сумын “Дарив-Эрчим хүч” ААТҮГ, “Орон сууц” ОНӨААТҮГ -ууд аудитад тайлангаа ирүүлээгүй. “Ундарга-Алтай” ААТҮГ 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр санхүүгийн тайлангийн аудит хийлгэх хүсэлтээ ирүүлсэн бөгөөд Төсвийн Ерөнхийлөн захирагчийн аудитад хамруулсан.

Хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа гаргаж ирүүлээгүй “Ундарга-Алтай” ААТҮГ-ын удирдлага, санхүүгийн ажилтанд сахилгын хариуцлага оногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж шийдвэрүүлсэн байна. “Дарив-Эрчим хүч” ААТҮГ-ыг хувьчилсан тул аудитаар шийдвэр өгөөгүй болно.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ыг, 2022 оны 10 дугаар тогтоолоор “Гэгээн-нуур” ААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан боловч татан буулгаж хаалтын баланс гаргаагүй байна.

САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР

Аймгийн хэмжээнд нийт 283 санхүүгийн тайлан гарснаас:

- Аудит хийж дүгнэлт өгсөн 143
 - Өөрчлөлтгүй санал дүгнэлт -85
 - Хязгаарлалттай санал дүгнэлт-58
- Түүвэрт хамрагдсан 138
- Аудитад хамрагдаагүй 2 санхүүгийн тайлан байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН АНГИЛАЛ

Нийт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 34,230.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 18,006.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан тайлагнуулсан.

АУДИТЫН ШИЙДВЭР

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 16,223.7 сая төгрөгийн зөрчлийн 1,217.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,899.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 62 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 89.9 сая төгрөгийн зөрчилд 216 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Мөн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 16.8 сая төгрөгийн асуудлыг МУЕА-т албан бичгээр уламжилсан.

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн 1,042.0 сая төгрөгийн зөрчил илэрч 302.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 98 төсөв захирагчдад, 739.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлагыг 188 төсөв захирагчдад, 74 заалт бүхий зөвлөмжийг 66 төсөв захирагчдад хүргүүлсэн.

“Ерөнхий чиглэлийн хэрэгжилт, үр дүн”-гийн дэлгэрэнгүй тайланг төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг тайлагнаж, хуулийн 6,7,8,9,10,11,15

дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажиллах төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналыг уламжилсан.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар 279 байгууллагын шилэн дансны цахим системийн 279 цэсийн хөтлөлтийг (www.fas.audit.mn) цахим системээр түүвэрлэн горим сорил хэрэгжүүлж, төсвийн шууд захирагчийн 45, Засгийн газрын тусгай сангийн 2, төрийн болон орон нутгийн өмчийн, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2 нийт 49 төсөв захирагчдад зөрчил арилгуулах албан шаардлага, төсвийн шууд захирагчийн 34, Засгийн газрын тусгай сангийн 11, төрийн болон орон нутгийн өмчийн 2, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1 нийт 48 төсөв захирагчдад зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт-23 байгууллагаас ирсэн албан бичгийн дагуу шилэн дансны цахим системийн цэс рүү орж тулган баталгаажуулахад 2023 оны байдлаар зөрчлийг арилгаж 80-95 хувь болжээ. Бусад байгууллагын хувьд албан шаардлагын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон 07 дугаар сарын 15-ны өдөр ирүүлэхээр байгаа тул биелэлтийг тооцоогүй болно.

Алтай сумын төсөв байгууллагуудын 2023 оны Шилэн дансны цахим системийн хөтлөлтийг явцын хяналтыг хэрэгжүүлж 1-5 дугаар сарын санхүүжилтийн гүйлгээ, 5.0 сая төгрөгийн орлогын гүйлгээ, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, төсвийн гүйцэтгэлийн 247.3 сая төгрөгийн мэдээллийг нөхөн шивүүлж зөрчлийг арилгасан.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ:

Санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэснээр байгууллагын санхүүгийн тайлан стандартын дагуу илэрхийлэгдэж төрийн байгууллага, ард иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаж шийдвэр гаргалтад нөлөөлсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн татварын тодорхойлолтын зөрүүтэй холбоотой 1,043.3 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, татварын цахим системд залруулсан байна.

Эхний хагас жилд тогтоосон 1,217.8 сая төгрөг, өмнөх оны 715.7 сая төгрөгийн төлбөрийн актаас 518.1 сая төгрөгийн актыг төлүүлж 1,415.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн оны 19,017.0 сая төгрөгийн албан шаардлагаас 3,544.0 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж 15,460.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хугацаа болоогүй байна. Өмнөх оны 14.1 сая төгрөгийн зөвлөмжөөс 1 заалт зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитын тайлант болон өмнөх оны аудитаар 1,355.9 сая төгрөгийн санхүүгийн, 43 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагууд албан бичиг, нотлох баримтаар хүлээн зөвшөөрсөн.

ГУРАВ.ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Гүйцэтгэлийн аудитын дүн:

Тайлант онд УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”, “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”, “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”- хийсэн гүйцэтгэлийн аудитыг 9 аудитор 219 хүн өдөр, 677 илүү цаг ажиллаж, 34.9 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна. Тайлант жилд хийсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан горим сорилыг бүрэн хэрэгжүүлж хугацаанд нь ҮАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт хүргүүлээ.

Гүйцэтгэлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл “хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ”-заалтыг 2023 оноос мөрдөх байгаа, “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн аудитад хамрагдсан нэгдсэн эмнэлэг-2, эрүүл мэндийн төв-22 байгууллагын хувьд санхүүгийн тайлангийн аудитаар үзсэн тул давхардуулан горим сорилыг хэрэгжүүлээгүй болно.

Гүйцэтгэлийн аудитаар 5,282.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1,335.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 26 заалт зөвлөмж, 28.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоожээ. Тайлант болон өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэрээс 19,766.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагууд албан бичиг, нотлох баримтаар хүлээн зөвшөөрсөн.

“Улс, орон төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн аудитын талаар:



Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, аймаг болон сумдын ЗДТГ, бусад холбогдох байгууллага, хуулийн этгээд хамрагдлаа. Тус аудитыг 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд 3 аудитор 70 хүн өдөр зарцуулан, 156 цаг илүү ажиллаж 7.7 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын үр дүн

“Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуульд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагаас шалтгаалан орон нутагт үүсэх үр өгөөж буурч, он дамжин хэрэгжиж байна” гэсэн дүгнэлт өгсөн. Нийт 2,817.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 14.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 943.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах 10 заалт бүхий албан шаардлага, 7 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, ҮАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт хүргүүлсэн.

Аудитаар Гүйцэтгэлийн-Нийцлийн аудитын газарт 1,859.6 сая төгрөгийн 3 саналыг нэгтгэсэн тайланд тусгуулахаар уламжилсныг аудитын нэгтгэсэн тайлан тусгасан байна. Аудитаар 1,873.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагууд албан бичиг, нотлох баримтаар хүлээн зөвшөөрсөн.

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн аудитын талаар:

Аудитад аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг хамрууллаа.

Тус аудитыг 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 19-ны өдрийг хүртэлх хугацаанд 5 аудитор 90 хүн өдөр зарцуулан, 1482 цаг илүү ажиллаж 19.6 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.



Аудитын үр дүн

Аудитаар "Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, хүн ам цөөн, алслагдмал орон нутгийн онцлогийг харгалзан санхүүжилт, төлбөрийн хэмжээг тогтоосноор иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахаар байна" гэсэн дүгнэлт өгч гэсэн дүгнэлт өгч 2,465.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 13.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 362.2 сая төгрөгийн 16 зөрчил арилгуулах албан шаардлага, 6 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аудитаар Гүйцэтгэлийн-Нийцлийн газарт 2,059.2 сая төгрөгийн 13 саналыг нэгтгэсэн тайланд тусгуулахаар уламжилсан.

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн аудитын талаар:

Аудитад аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын ЗДТГ, хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд болон төслийн удирдах хороо, төслийн нэгж, хэрэгжүүлэгч холбогдох байгууллагын үйл ажиллагаа, зээл, тусламжийн хөрөнгийн 2016-2022 оны хугацаан дахь ашиглалт, үр дүнг хамруулсан.

Тус аудитыг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 3 аудитор 69 хүн өдөр, 1.3 сая төгрөгийн өртөгтэйгөөр гүйцэтгэж байгаа тооцоо гарч байна.

Аудитад хамрагдах төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт, гэрээ, хяналт нь төсөл хэрэгжүүлэгч нэгж, холбогдох яам газруудаар дамжин хэрэгжсэн. "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл", "Монгол малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийн 2 дугаар үе шат", "Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл", "Бүгд найрамдах Беларусь Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл", "Ногоон алт малын эрүүл мэнд" төслүүд аймагт хэрэгжсэн байна. Говь-Алтай аймагт хэрэгжиж буй төслийн аудитын багаас ирүүлсэн баримт материалтай танилцаж, горим сорилыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үе шат 90 хувьтай байна.

Аудитын үр дүн

“Улс, орон төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн аудитаар Гүйцэтгэлийн-Нийцлийн аудитын газарт 1,859.6 сая төгрөгийн 3 саналыг нэгтгэсэн тайланд тусгуулахаар уламжилсныг аудитын нэгтгэсэн тайлан тусгасан байна. Үүнд:

- ❖ Ахмадын холбоо, сувиллын барилга, Дэлгэр сумын сумын төвийн шинэчлэл, Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3, Есөнбулаг сумын Жишиг гудамж тохижилт, Халиун сумын Цэцэрлэгийн барилга, Есөнбулаг сумын Цэнгэлдэх хүрээлэн, Хөхморьт сумын Соёлын төвийн барилгын их засварын ажил 15,258.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ нь өмнөх онуудад хэрэгжиж байсан боловч Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй, цаашид хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүйгээр ажил зогссон байгааг нэгдсэн тайлант тусгуулсан.
- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдаж буй асуудлыг нэгдсэн тайланд тусгасан.

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн аудитаар Гүйцэтгэлийн-Нийцлийн газарт 2,059.2 сая төгрөгийн 13 саналыг нэгтгэсэн тайланд тусгуулахаар уламжилсан.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

Эхний хагас жилд тогтоосон 28.1 сая төгрөг, өмнөх оны 209.2 сая төгрөгийн төлбөрийн актаас 11.0 сая төгрөгийн актыг барагдуулж 226.37 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн оны 93,055.1 сая төгрөгийн албан шаардлагаас 31,553.7 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж 61,501.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хугацаа болоогүй байна. Өмнөх оны 3,280.8 сая төгрөгийн зөвлөмжөөс 29 заалт зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Гүйцэтгэлийн тайлант болон өмнөх оны аудитаар 19,766.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагууд албан бичиг, нотлох баримтаар хүлээн зөвшөөрсөн.

ДӨРӨВ. НИЙЦЛИЙН АУДИТ

Тайлант онд УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалга, нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”, “Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж тайлагнах”-д хийсэн нийцлийн аудитыг 8 аудитор 280 хүн өдөр, 1741 илүү цаг ажиллаж, 30.9 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна. Тайлант жилд хийсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан горим сорилыг бүрэн хэрэгжүүлж хугацаанд нь аймгийн ИТХ, Засаг дарга, Байгаль орчны аялал жуулчлалын газарт газарт хүргүүлээ.

Нийцлийн аудитаар 3,729.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 950.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 66 заалт бүхий 2,778.3 сая төгрөгийн зөвлөмжийг өгчээ.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитын талаар:



Аудитад Татварын Ерөнхий газар, аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Усны сав газрын захиргаа, Сум дундын ойн ангийн 2021-2023 оны БНАТ-ийн хуулийн хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааг хамруулсан. Тус аудитыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд 8 аудитор 280 хүн өдөр зарцуулан, 1741 цаг илүү ажиллаж 30.9 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж

гүйцэтгэсэн байна.

Аудитын үр дүн

Аудитаар "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт 2021 онд 81 хувь, 2022 онд 27 хувьтай байна" гэсэн дүгнэлт өгч гэсэн дүгнэлт өгч 3,729.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 950.9 сая төгрөгийн 119 зөрчил арилгуулах албан шаардлага, 7 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

"Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх"-д хийх аудитын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар 279 байгууллагын Шилэн дансны цахим системийн 279 цэсийн хөтлөлтийг 100 хувь хамруулан горим сорил хэрэгжүүлснээр 15,451.6 сая төгрөгийн 1008 гүйлгээг огт мэдээлээгүй, 480.5 сая төгрөгийн 55 гүйлгээг хугацаа хоцруулан шилэн дансны цахим системд шивсэн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд төсвийн шууд захирагчийн 40, Засгийн газрын тусгай сангийн 2, төрийн болон орон нутгийн өмчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1 нийт 42 төсөв захирагчдад зөрчил арилгуулах албан шаардлага, төсвийн шууд захирагчийн 32, Засгийн газрын тусгай сангийн 11, төрийн болон орон нутгийн өмчийн 2, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2 нийт 47 төсөв захирагчдад зөвлөмжийг санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлттэй хамт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Алтай сумын төсөв байгууллагуудын 2023 оны Шилэн дансны цахим системийн хөтлөлтийг явцын хяналтыг хэрэгжүүлж 1-5 дугаар сарын санхүүжилтийн гүйлгээ, 5.0 сая төгрөгийн орлогын гүйлгээ, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, төсвийн гүйцэтгэлийн 247.3 сая төгрөгийн мэдээллийг нөхөн шивүүлж зөрчлийг арилгасан.

Зураг 1 Алтай сумын төсөвт байгууллагуудад Шилэн дансны цахим систем хөтлөлтийн



талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байгаа

нь

НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

Өмнөх оны нийцлийн аудитаар өгсөн 111.8 сая төгрөгийн төлбөрийн актаас 4.4 сая төгрөгийг хэрэгжүүлсэн байна. Актын үлдэгдлийн 42 хувь нь Сум хөгжүүлэх сан 58 хувь Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой байна. Өмнөх онуудад өгсөн 26.1 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжих шатандаа байна. Нийцлийн аудитаар өгсөн шийдвэрээс 4.46 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрсөн.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг удирдан хийж гүйцэтгэж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хяналт хийх арга зүй, чиглэл нэг болсон.

ЗУРГАА. ДОТООД АЖИЛ

Бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн талаар:

МУЕА-ын тушаалаар үндсэн 13 орон тоог баталсан бөгөөд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах гэрээт 5 ажилтан нийт 17 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Үндсэн орон тоонд санхүүгийн мэргэжилтэй 11, хуульч эрхзүйч 1, төрийн удирдлага мэргэжилтэй 1 ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байна. Мөн Төрийн удирдлага мэргэжлээр мэргэшсэн 3, мэргэшсэн нягтлан бодогч 7, магистрын зэргээ хамгаалсан 10 албан хаагч байна.

Япон Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгждэг Монгол Улсын төрийн албаны хүний нөөцийг дэмжих JDS тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад ахлах аудитор Б.Цэвэлмаа тэнцэж тус улсын их дээд сургуулийн магистрын хөтөлбөрт сурахаар боллоо. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан тэтгэлэгт шалгарсан суралцагч, түүнийг илгээгч байгууллага, хөтөлбөрийн Удирдах зөвлөлийн хооронд байгуулах гурван талт гэрээнд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр оролцлоо.



Зураг 2 Гурван талт гэрээнд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ

Аудитор Э.Сүнжидмаа, Г.Энхдэлгэр нар Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч боллоо.

Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж улирал бүр ажлыг дүгнэлээ. Ажилтнуудын хандлага ёс зүйн үнэлгээг хамт олон болон шалгуулсан байгууллагын албан хаагч нараас санал асуулга авч дүгнэсэн болно. Төрийн албан хаагчдын хүний нөөцийг судалгааг Үндэсний аудитын газрын (www.hr.audit.mn) болон Төрийн албаны зөвлөлийн (www.hrm.csc.gov.mn) системд байршуулаад байна.

“Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийн хүрээнд албан хаагчдын ажлын байранд ажиллах эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Алба хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрууллаа.

Эхний улирлын гүйцэтгэлийн үнэлгээгээр бүрэн хангалттай, хангалттай үнэлгээ авсан албан хаагчдад 7.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тооцон олгосон.

Авлигын эсрэг хөтөлбөрийн биелэлтийн талаар:

Төрийн аудитын байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2023 оны эхний хагас жилд 8 арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Үүнд:

- Албан хаагчдын 2022 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бүрэн гаргуулан баталгаажуулж мэдээг Захиргаа, хууль, эрх зүйн газарт хүргүүлсэн.
- Тайлант оны 2023 оны 01 дүгээр 10, 03 дугаар сарын 17, 04 дүгээр сарын 19, 05 дугаар сарын 12, 30, 06 дугаар сарын 13, 19, 20-ны өдрүүдэд Авлигатай тэмцэх газар болон Үндэсний аудитын газраас бэлтгэсэн нийт 20 мэдээллийг "Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар" фэйсбүүк хуудсанд шейр хийх байдлаар байршуулж нөлөөллийн арга хэмжээг авсан. Авлигатай тэмцэх газраас санаачлан зохион байгуулж буй "Авлигын Эсрэг Нэгдье" аянд оролцон 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр байгууллагын фэйсбүүк хуудсанд зурагт хуудас, видео шторкуудыг байршуулж, албан хаагчдаар түгээлгэсэн.
- Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас зарласан уралдаанд ирсэн сурагч Д.Одгэрэлийн "Авлигын далд ертөнц ба үнэн учир" сэдэвт зургийг фэйсбүүк хуудсаар дамжуулан 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр олон нийтэд танилцуулсан.
- Төрийн аудитын байгууллагын зорилго, чиг үүрэг, авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан томилолтоор сумдад ажиллахдаа санхүүгийн ажилтан нарт зөвлөмж өгч ажиллалаа.
- Алтай сумын төсөвт байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн туслах ажлыг гүйцэтгэсэн.
- Эхний хагас жилийн байдлаар хувийн аудитын хуулийн этгээд болон шалгагдагч этгээдтэй 62 гэрээг байгууллаа. Тус гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийн 1.7-т "Авлигал болон залилан мэхлэх үйлдэл" гэж тусгасан.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд эхний хагас жилийн 56 мэдээлэл оруулаад байна. Хугацаа хоцорсон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй.
- Иргэдээс байгууллагын үйл ажиллагааг үнэлэх зорилгоор [google.forms](https://www.google.com/forms) ашиглан 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн санал асуулга авсан. Санал асуулгад 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 31 иргэн хамрагдсан.
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 28 мэдээллийн [audit.mn](https://www.audit.mn) цахим хуудас болон "Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар" фэйсбүүк хуудсанд байршуулсан.

Ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийн мөрдөлт:

Аудиторуудын хараат бус байдлыг хангах, авлига, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхааран ажиллаж байна. Зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно. Түүнчлэн аудит хийхэд нөлөөллийн мэдүүлгийн талаар шалгагдагч этгээдэд танилцуулан гарын үсгээр баталгаажуулж бүртгэл хөтөлж хэвшээд байна.

“Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги”-ийг 2023 оны төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд дараах арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний 3.4-т “Аудитын тайлан, үр дүнг иргэд, олон нийтэд зориулан инфографик хэлбэрээр боловсруулах мэдлэг, чадвартай албан хаагчийг нэмэгдүүлэх” сургалтад хамрагдах хүсэлтийг гаргаж сургалтад хамрагдаж байна.
- Эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэсэн 140 аудитын хураангуй тайланг open.audit.mn сайтад бүрэн байршуулсан. Түүнчлэн санхүүгийн тайлангийн танилцуулгаар 2023 оны 06 дугаар 19-ний өдөр, "Орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын аудит"-аар 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр инфографик хийж олон нийтэд түгээсэн. Мөн 2023 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын танилцуулгыг визуал хэлбэрээр фэйсбүүк хуудсаар дамжуулан 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр түгээсэн.



Зураг 3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитын инфографикийн хэсгээс

“Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх харилцагч талуудын оролцооны стратеги”-ийг 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд 5 арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ. Үүнд:

- Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас 2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналыг [google.form-оор](#) дамжуулан 69 иргэнээс авлаа. Ирүүлсэн саналаас хамгийн өндөр санал авсан 3 сэдвийг хэлэлцүүлэн журмын дагуу үнэлж ҮАГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.
- Олон нийтийн Алтай радиод 3 дугаар сарын 20-ны өдөр аудитын үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээлэл хийсэн. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийх гүйцэтгэлийн аудитын талаар 2023 оны 06 сарын 20-ны өдөр Монголын Үндэсний теле



Зураг 4 МҮОНТ-ийн ярилцлага

мэдээлэл хийсэн. Аудитын үйл ажиллагааны талаар 2 хэвлэлийн мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудас болон “Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар” фэйсбүүк хуудсаар мэдээллээ.



Зураг 5 <https://heyzine.com/flip-book> хуудсанд байршуулсан СТА-ын танилцуулга

- Төрийн аудитын газраас 2023 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын танилцуулгыг сэтгүүл хэлбэрээр олон нийтэд түгээлээ.
- Аудитын иргэдийн бүлгийн гишүүд нь аудитын сэдвийн саналыг тайлант оны 5 дугаар сард 100 иргэнээс цаасан хэлбэрээр авсан. Ирүүлсэн саналыг 2024 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналд тусгасан.
- Тайлант оны 03 дугаар сарын 20-ны өдөр эрүүл мэндийн салбарын байгууллагын албан хаагч нарт санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийтлэг зөрчлийн талаар танилцууллаа. Мөн Шарга, Төгрөг, Бугат, Тонхил, Дарив, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдад 3 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд томилолтоор ажиллан албан хаагч нарт сургалт хэлэлцүүлэг хийлээ.
- Хоршоо хөгжүүлэх сангийн гэрээний хугацаа хэтэрсэн 36 зээлдэгчийн 194.5 сая, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн гэрээний хугацаа хэтэрсэн 1 зээлдэгчийн 56.3 сая, Мал хамгаалах сангийн хугацаа хэтэрсэн 31 зээлдэгчийн 31.5 сая, Тариалан эрхлэгчдийг дэмжих сангийн хугацаа хэтэрсэн 56 зээлдэгчийн 77.9 сая төгрөгийн, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Захиргааны хуулийн 103 дугаар зүйлд заасан төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр гарсан шийдвэрийг аймгийн Прокурорын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр удирдамжийн дагуу хүргүүллээ. Дээрх хохирлыг нөхөн төлүүлэхээр ажиллагаа хийгдэж байна.

Сургалтын талаар:

Эхний хагас жилийн байдлаар нийт 32 төрлийн сургалт зохион байгуулагдсанаас Төрийн аудитын байгууллагын сургалт, хөгжлийн төлөвлөгөөний дагуу 18 сургалт, байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 9 сургалт, гаднын бусад байгууллагаас зохион байгуулсан 5 сургалт байна.

ТАБ-ын 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалт:

УАГ-аас удирдах ажилтнуудад зориулсан "Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны сургалт-2023", "Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийн арга зүй" сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер нар танхимаар хамрагдсан.

ҮАГ-аас шинэчлэн баталсан журам, заавартай холбоотой сургалт, нэгдсэн удирдамжаар хийж байгаа аудитын талаар хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгуулж 11 албан хаагчид хамрагдсан.

Төрийн аудитын сургалт, хөгжлийн системийн цахим сургалтад албан хаагчдыг хамруулах

Шинэ албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” 3 кредит цагийн сургалтад аудитор М.Дөлгөөнбаяр цахимаар суралцаж сертификат авсан. “Төрийн албан хэрэг хөтлөлт” цахим сургалтад аудитын менежер, архивын ажилтан, бичиг хэргийн ажилтан нар хамрагдаж сертификат авсан.

Мөн албан хаагчид 7 хоногийн бүхийн лхагва гарагийн 8 цагт Excel, Dashboard, Power Bi, Дата анализ болон Data science-ийн системтэй мэдлэг, ур чадварыг олгох сургалтыг Data School (<https://data-school.mn/>) цахим сайтын сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалтаар олж авсан мэдлэгээ аудитын болон өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Байгууллагын 2023 оны дотоод сургалтын төлөвлөгөөг батлуулж, хангаж ажиллах

Байгууллагын 2023 оны дотоод сургалтын төлөвлөгөөг оны эхэнд 4 төрлийн 17 сургалтыг батлуулсан. Эхний хагас жилийн байдлаар 11 сургалтыг зохион байгуулагдахаас бүх сургалт явагдаж 100 хувийн хэрэгжилттэй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатны ажилбарын хүрээнд боловсрол, эрүүл мэндийн салбарын төсвийн мэргэжилтэн, төсвийн ерөнхий нягтлан бодогч, сумдын санхүүгийн албаны дарга нартай 2022 оны төсвийн жилийн онцлог асуудал, шинээр батлагдсан хууль, сайдын тушаал шийдвэр, журам заавар, өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, улсын төсөвт байгууллагуудын эрсдэлтэй асуудал, Санхүүгийн тайлангийн аудитын тайлан, хураангуй тайланг хэрхэн бэлтгэх талаар 4 удаагийн сургалтыг дотооддоо зохион байгуулсан.



Зураг 6 Дотоод сургалт хэлэлцүүлэг

Ажилчдын суурь мэдлэг, хувь хүний хөгжлийг дээшлүүлэх зорилгоор англи хэлний анхан, дунд шатны сургалт, Excel программын ахисан шатны сургалтыг зохион байгуулж нийт ажилчид хамрагдсан.

Гаднын байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах

Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050” сэдэвт сургалт, Өрхийн эрүүл мэндийн төвөөс “Эрүүл мэнд хөдөлгөөн, зөв хооллолт” сэдэвт сургалт, Санхүүгийн

зохицуулах хорооноос Санхүүгийн зах зээлийн хөгжил ба иргэдийн оролцоо” сэдэвт сургалт, “JCI”-ийн сургалтад ажилчид хамрагдсан.



Зураг 7 Сургалт, хэлэлцүүлэг

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтад 4 аудитор хамрагдаж улмаар шалгалт өгөн аудитор 1 аудитор 2 шалгалтын хөнгөлөлт, 2 аудитор мэргэшсэн нягтлан бодогч болсон.

Мэдээ, мэдээлэл, судалгаа ил тод байдлын талаар:

Тайлант жилд хийсэн аудитын тайлан, зөвлөмжийг олон нийтэд мэдээлэх, байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Тухайлбал:

- Өмнөх онд гүйцэтгэсэн гүйцэтгэл, нийцлийн 2, тайланд онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн аудитын 202 тайланг (www.audit.mn) цахим хуудас, "Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар" фейсбүүк хуудсаар олон нийтэд мэдээлсэн. Түүнчлэн цаг үеийн шинжтэй 9 мэдээллийг бэлтгэн мэдээлж, Үндэсний аудитын газрын цахим сайтад байршуулсан 10 мэдээллийг олон нийтэд түгээлээ.
- МУЕА-ын 2022 оны А/75 тоот тушаалаар батлагдсан санал дүгнэлт гарах 143 санхүүгийн тайлангийн аудит, нэгдсэн удирдамжаар хийгдсэн 2 гүйцэтгэл, 1 нийцлийн аудитын хураангуй тайланг бэлтгэсэн. Санхүүгийн тайлангийн аудитын 140 www.open.audit.mn сайтад байршуулсан. Хилийн цэргийн 0214-р анги, Зэвсэгт хүчний 304 дүгээр тусгай рот нууцын байгууллага, "Дарив Эрчим хүч" ААТҮГ нь аудит тайлангаа ирүүлээгүй тул аудитад хамрагдаагүй 3 хураангуй тайланг олон нийтэд мэдээлээгүй

ТАБ-ын Мэдээллийн технологийн талаарх бодлого чиглэл, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах

- Санхүүгийн тайлангийн аудитын системд (www.fas.audit.mn) санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт гаргах 283 санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны ажилбар, гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажилбарыг 100 хувийг оруулсан.
- Санхүүгийн тайлангийн аудитын системд (www.fas.audit.mn) санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг оруулж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.
- Гүйцэтгэл, нийцлийн аудитын (www.data.audit.mn) сайтад нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа 6 аудитын төлөвлөлт болон гүйцэтгэл, тайлагналын явцын мэдээллүүдийг 14 хоног тутамд байршуулсан.
- Оффис 365 программыг аудитын менежер, мэдээлэл технологи хариуцсан аудитор нар үйл ажиллагаандаа ашиглаж байна.

- Teams, Viber, (www.audit.mn) системүүдийг ашиглан ҮАГ-тай мэдээ, мэдээлэл солилцож хэвшсэн.
- Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрээр хөтлөн явуулж байна. Үүнд: Үндэсний аудитын газрын холбогдох нэгжүүд болон бусад байгууллагуудаас ирсэн 538 баримт бичгийг (www.able.audit.mn) программаар хүлээн авч, ангилан бүртгэж цахимаар цохолт хийж хариуцах ажилтанд шилжүүлж ажиллалаа. Мөн тайлант хугацаанд 364 баримт бичгийг холбогдох байгууллагуудад цахимаар хүргүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавилаа.
- Эхний хагас жилд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудит, 3 гүйцэтгэл, 1 нийцлийн аудитын ажлыг баримтыг google drive программ ашиглаж гүйцэтгэж нэгтгэлээ.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын талаар:

Захиргааны ерөнхий хуулийн 103, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, нөлөөллийн мэдүүлгийн судалгааг хийсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 16.8 сая төгрөгийн 1 асуудлыг МУЕА-т 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 175 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Шүүхэд хүсэлтийн дагуу 4 баримт материалыг хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан хүргүүллээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Тайлант жилд байгууллагын албан хэрэг, хөтлөлтийн талаар дараах ажлуудыг зохион байгууллаа.

- Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг MNS-2011:2140 баримт бичгийн стандарт, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт нийцүүлж хөтөлсөн.
- Байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ирсэн 538, явсан 364 бичгийг журмын дагуу бүртгэл хөтөлж, албан хэрэг хөтлөлтийг цаасаар болон цахимаар хослуулан бүртгэсэн.
- Хариутай бичгийн шийдвэрлэлтийн эргэцийн мэдээг 14 хоног тутам буюу 12 удаа тайлагнасан.
- Өргөдөл, гомдол, хүсэлтийн мэдээ, тайланг сар тутам буюу 6 удаа тайлагнасан.
- Эхний хагас жилд хариутай 38 албан бичиг, 11 өргөдөл гомдлыг шийдвэрлэн, хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээнд хяналт тавьж ажиллалаа.
- Хэвлэмэл хуудасны тооцоог гаргахад тушаал, А4, А5 албан тоот, албан шаардлага, актын бланк нийт 5,146 ширхэг байснаас 4,607 ширхэг зарцуулж, 180 ширхэг албан бланк устаж 359 хэвлэмэл хуудасны үлдэгдэлтэй байна.
- Мэдээлэл лавлагааны баримт бичигт илтгэл 1, илтгэх хуудас 2, танилцуулга 1, зохион байгуулалтын баримт бичигт хурлын тэмдэглэл 4 баримт бичгийг жагсаалтын дагуу pdf хэлбэрээр компьютерын хард дискт бүрэн хадгалсан.
- Аудитын үйл ажиллагаа, тайлан шийдвэртэй холбоотой 8 баримт материалыг хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан хүсэлт гаргасан байгууллага, иргэнд өглөө.

Тайлант жилд байгууллагын архивын талаар дараах ажлуудыг зохион байгууллаа.

- Байгууллагын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталсан.
- Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу 3 албан тушаалтнаас 91 байнга хадгалах хадгаламжийн нэгжийг хүлээн авч данс бүртгэлд тусгалаа.
- Байгууллагын архиваас жилийн эцсийн байдлаар 49 хадгаламжийн нэгжийг албан тушаалтнуудад бүртгэлээр түр олгожээ.
- Байгууллагын архивд 2023 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар хадгалагдаж байгаа 2023 оны 91 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэн баримтыг хадгаламжийн нэгжийн дугаар бүрээр "PDF" өргөтгөлтэйгөөр 91 хавтас үүсгэж компьютерт болон DVD хуулж хадгаллаа.

Өргөдөл гомдол

Тайлант онд байгууллагын хэмжээнд санал, гомдол ирээгүй, аудиттай холбоотой 4, албан хаагчийн 7 нийт 11 өргөдлийг шийдвэрлэсэн байна.

Мэдээлэл солилцох урсгал

МУЕА түүний орлогчоос өгсөн үүрэг чиглэл, төрөлжсөн аудитын газраас болон бусад газруудаас ирүүлсэн албан, бичиг, судалгаа, саналыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- МУЕА-ын тушаал, удирдах ажилтны зөвлөгөөн, семинар, хурал зөвлөгөөнөөс өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөө гарган гүйцэтгэлд хяналт тавьж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Teams программд 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр, 06 дугаар сарын 30-ны өдөр тус тус байршуулсан. Мөн 14 хоногийн ажлын тайланг хугацаанд хүргүүлсэн.
- Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт хандаж “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийх гүйцэтгэлийн аудитын акт, албан шаардлагын төслийг хянуулж зөвлөгөө авлаа.
- Гүйцэтгэл-нийцлийн аудитын газраас нэгдсэн удирдамжаар хийсэн 2 гүйцэтгэлийн аудитын 6 удаагийн сургалт хэлэлцүүлэгт албан хаагчид хамрагдсан.
- Мэдээлэл технологийн газраас хийсэн шилэн дансны программд 283 байгууллагын мэдээллийг орууллаа.
- Хүний нөөцийн цахим системд алба хаагчдын мэдээллийг шивж оруулсан.
- Үндэсний аудитын газраас ирүүлсэн цаг үеийн үүрэг, даалгавар, мэдээ, судалгаа, шийдвэрлэлтийг бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.
- Байгууллагын 14 хоногийн шуурхай хурлаар өгсөн үүрэг даалгаврын бүртгэл хөтлөн, биелэлтийг тооцож байна.
- Байгууллагын 12 хэрэглэгч мэдээллийн технологи үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд техникийн болон мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл учраагүй.
- Teams, Viber, (www.audit.mn) хаягаар мэдээлэл солилцох, (www.fas.audit.mn), (www.surgalt.audit.mn), (www.local.audit.mn) системүүдийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Байгууллагын сүлжээ болон мэдээлэл тээгчид цахим халдлагад өртөөгүй. Шаардлагатай дуудлагыг auditmn-my.sharepoint.com ашиглан өгч байна

Нууцын талаар

Төрийн аудитын байгууллагын төрийн албаны нууцыг хамгаалах дотоод журмын хэрэгжилтийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Нууцын баталгааг 12 ажилтнаас 2023 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн дотор гаргуулан авсан
- Нууц хамгаалан ажлын тайланг Үндэсний аудитын газар болон Тагнуулын Ерөнхий газрын аймаг дахь салбарт хүргүүллээ. Тайлант хугацаанд зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно.

Ажилдаа нэвтрүүлсэн шинэлэг ажлууд, бидний амжилт

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь эхний хагас жилд онцлон дурдвал дараах шинэлэг, бүтээлч ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Олон нийтийн сүлжээгээр анхаарал татсан асуудлаар мэдээллийн сан үүсгэж аудитад ашиглаж байна.
- Байгууллагын ажилтнууд, иргэдэд хандсан мэдээлэл хийх, төсөв санхүүгийн хяналт тавих мэдлэг олгох, сумдын төсөвт байгууллагуудад зөвлөн туслах үйл ажиллагааг үзүүлсэн.
- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, аудитын тайлан, албан бичгийг цахимаар харилцагч байгууллагуудад хүргүүлснээр бичиг хэрэг, цаасны хэрэглээг бууруулж 2.4 сая төгрөгийг хэмнэсэн байна.
- Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн татварын тодорхойлолтын зөрүүтэй холбоотой 1,043.3 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, татварын цахим системд залруулсан байна.
- Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэгдээгүй 990.4 сая төгрөгийн зөрчлийн арилгаж нөхөн шивүүлсэн.
- Санхүүгийн тайлангийн танилцуулгаар аймгийн Засаг даргад Засгийн газрын 326 дугаар тогтоолын дагуу сумын ЗДТГ-ын нягтлан бодогчийн ажлын ачааллыг харгалзан орон тоо, цалин нэмэгдлийг хуулийн хүрээнд шийдвэрлэх саналыг хүргүүлсэн.
- Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад 2 аудитор тэнцэж Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч болсон. Япон Улсад 1 аудитор магистрын чиглэлээр суралцахаар болсон

ДОЛОО.САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

МУЕА-ын төсвийн багцаас 2023 оны төсвийн жилд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын урсгал зардалд эхний хагас жилээр 340.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан нь төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодитой дэмжлэг болж төсвийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнг хуулийн

дагуу тайлагнаж ажиллав. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Төсвийн шууд захирагчийн үүргийг дарга бөгөөд тэргүүлэх аудитор гүйцэтгэж байна.

Төсвийн санхүүжилтийн, хэтрэлт, хэмнэлтийн талаар :

Эхний хагас жилийн байдлаар 340.9 сая төгрөгийн санхүүжилт авахаар батлагдаж 276.3 сая төгрөгийн зарцуулах эрх үүсэж, санхүүжсэн. Батлагдсан төсвийг зохих хууль журам, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж нягтлан бодох бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан мэдээг зохих цаг хугацаанд нь гаргаж хэрэглэгч болон удирдлагыг санхүүгийн мэдээллээр бүрэн ханган ажиллаж байна.

Төсвийн үр ашигтай зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр болон санхүүгийн тайлагналын хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэмнэлт үүсгэж 81 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах, Төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах үүднээс өөрийн санхүүгийн үйл ажиллагааны зарцуулалтыг www.shilendans.gov.mn цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн. (<https://shilendans.gov.mn/org/1432>)

Санхүүгийн тайланд өгсөн хараат бус аудиторын дүгнэлт

Манай байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй санал дүгнэлт" авсан. Аудитаар нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын ангиллаас санхүүжүүлж эдийн засгийн ангиллыг зөрүүтэй тайлагнасан зөрчилд "Эдийн засгийн ангилал зөрүүтэй зарцуулалт хийхгүй байх, холбогдох журмыг мөрдөж ажиллах" зөвлөмж өгсөн. (Санал дүгнэлтийг хавсаргав.)

НАЙМ. ДҮГНЭЛТ, САНАЛ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЕС. ХАВСРАЛТ

ᠡᠰᠡᠰᠡᠷᠠᠯᠲᠤ